

ГАДААД МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ЗАСГИЙГ УСТГАСАН ТҮҮХИЙН АСУУДАЛД

Н.Хишигт

Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэн

Өгүүллийн товч: Энэхүү өгүүлэлд Гадаад Монголын автономит засаг унасан шалтгааныг бүс нутгийн үйл явдал хийгээд дотоод дахь засаглалын хямралын үр дагавартай холбон тайлбарлаж, тусгаар байдлын сүүлчийн илэрхийлэл болж байсан өөртөө засах засгаа хэвээр үлдээхийн тулд Богд Жибзундамба тэргүүтэй Монголын эрх баригчдаас хэрхэн чармайж байсныг сүүлийн үеийн судалгааны үр дүн, шинэ баримт материалд тулгуурлан харуулахыг оролдсон болно.

Түлхүүр үг: Гадаад Монгол, өөртөө засах засаг, бүс нутгийн байдал, Богд Жибзундамба, Хиагтын гэрээ, Нармай Монголын хөдөлгөөн, хар шарын тэмцэл, Чен И, Б.Цэрэндорж, "64 зүйл гэрээ", монголчуудын хүчин чармайлт, Сүй шу жан

1910-аад оны дундаас Монголын эргэн тойронд өрнөсөн олон үйл явдал тус орны улс төрийн байдалд сөргөөр нөлөөлж, Хиагтын гурван улсын гэрээгээр баталгаажсан Гадаад Монголын автономит засаг ахархан боловч хугацаанд унасан нэгэн үе тохиосон билээ. Энэ нь нэгэн үед бидний хялбарханаар ойлгож байсан зүйл огт бус, харин ч олон янзын хүчин зүйлээр нөхцөлдсөн ихээхэн ээдрээтэй үйл явц байж, түүнийг монголчууд бололцоотой бүхий л аргаар сөрөн зогсохыг хүчлэн чармайсан нь эдүгээ улам тодорхой болж байна.

Гадаад Монголын өргөн эрхтэй, өөртөө засах засаг унасны уг сурвалж нь ДИУ-аас Монголын талаар явуулж байсан бодлого, үйл ажиллагаатай холбогдох нь тодорхой. Хятад, Орос, Монгол гурван улсын гэрээ батлагдмагц 1915 оны 6-р сарын 16-наас 22-ны хооронд Хүрээнд хэрэг эрхлэх сайдаар Чен Лу, Улиастай, Ховд, Хиагтад туслах сайд нар суух болж, тэднийг сахин хамгаалах нэрийн дор нийт 350 хятад цэрэг Монголд байрлах болсон билээ. Энэ нь ДИУ-ын зүгээс Монголын талаархи далдын санаархлаа илээр хэрэгжүүлэх боломж бололцоог нээсэн хэдий ч тэрбээр "эзэн эрхийн доорхи харъяат нутаг"-ийнхаа тухайд эрс шийдэмгий бодлого явуулж чадахгүй байв.

Юуны өмнө, Хиагтын гэрээ Гадаад Монголын оршин тогтнол, үндэсний өвөрмөц байдал, дотоод хэрэгтээ бүрэн бие даах нөхцлийг хангах баталгаа болж байсан бөгөөд Хятадын дотоод дахь цэргийн эрхтнүүдийн тэмцэл үргэлжилж, Бавуужавын бослого Бээжингийн Засгийн газрын анхаарлыг Өвөр Монголд хандуулж, хөрөнгө, хүч хаяхад хүргэжээ. Эл нөхцөлд Хятадын зүгээс Монголын талаар явуулах бодлого нь улс төр, эдийн засгийн аргыг хавсран хэрэглэх замаар монголчуудад дарамт үзүүлэх явдлаар тодорхойлогдож байв.

Бүр 1915 оны дундаас Богдыг хаан өргөмжлөх, бусад ноёд, ихэс дээдсийг дэвшүүлэх явдлыг Хятадын Ерөнхийлөгчийн эрх мэдлийн асуудал мэтээр тулгахыг оролдож эхэлсэн ба Монгол дахь Хятадын улс төрийн эрх мэдэл сэргэхийн хирээр хятад худалдаачид буцан ирж худалдаа мөнгө хүүллийн ажлаа дэлгэрүүлэн, 1911-1912 оны үйл явдлаар хохирсон хэмээн тооцоо бодож эхэлжээ. Тэдний үйл ажиллагаа нь дан ганц хувийн пүүс хоршооны хэрэг биш бөгөөд цаанаасаа төрийн бодлогоор тэтгэгдэж байсан гэж үзэх ёстой.

Тэгвэл Богд Жибзундамба тэргүүтэй монголын эрх баригчид Бээжинтэй харилцах харилцаандаа онцын өөрчлөлт оруулаагүйн дээр дотоод хэрэгтээ Хиагтын гэрээний заалтыг чанд баримталж, зарим тохиолдолд бараг туурга тусгаар улсын хэмжээнд хандахыг эрмэлзсэн байдал ажиглагдана. Энэ тухай Монголын Гадаад хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас Богд хаанд өргөсөн "Думдад, Орос, Монголын гэрээ бичгийн утга чанарыг тайлбарласан дэвтэр"-т "... бидний улс хэдий Думдад улсын хэмжээтэй эзэрхэхийг хүлээсэн боловч улс төрийн байдлаа алдсан явдал огт үгүй. ...Думдад улсаас бидний дотоод засгийн буй бүхий хэрэгт оролцох эрх үгүй" (1.9) хэмээн зааж, түүнийг аливаад баримтлахыг хичээж байжээ. Тухайлбал, Гурван улсын гэрээ ёсоор Думдад улсын Ерөнхийлөгч өөрийг нь Гадаад Монголын Жибзундамба хутагт хаан болгон

өргөмжилсөн тухай зарлан ирсэнд Богд хаан талархал илэрхийлсэн хэдий ч "... Гадаад Монголын олон засаг ноёд хан, ван бэйл, бэйс, гүн нарыг хэргэм зэрэг дэвшүүлэх" гэснийг гэрээний 5-р зүйлд үл нийлэлцэх тул зөвшөөрөн хүлээж чадахгүй гэсэн хариултыг өгсөн (2.95) нь асуудлыг дотоодын хэрэг хэмээн үзсэнийх байв.

Түүнчлэн шагнасан Алтан тамга, навчит өргөмжлөлийг хүлээж авахгүй цааргалсаар байсан нь түүхэнд тодорхой үлджээ.

1915 оны 8-р сард ДИУ-ын сайдаас Богдод тамга өргөмжлөл гардуулахаар Бээжингээс тусгай элч ирэх болсоныг мэдэгдсэнд "...автономит Монголын Засгийн газар гэрээ бичигт алтан тамга, навчит өргөмжлөлийг олгох тухай заалт байхгүй" хэмээн эсэргүүцэн хүлээж авсангүй (2.94). Цаашид Дундад Улсын зүгээс шамдуулах бүрд Монголын тал аль болохоор арга саам хийн хойшлуулсаар байсныг доктор Л.Жамсран хятадын түүхч Чен Цун зо-гийн номд тулгуурлан нилээд тодорхой өгүүлсэн байдаг. Тэнд бичсэнээр: 1915 оны мөн оны 10-р сарын эхээр Хүрээнд ирж, тушаалын албыг эхэлсэн Чен Лу-д "өргөмжлөлийн хэрэг нэгэнт дууссан"-ыг Автономит Монголын Гадаад яамны дэд сайд Ширниндамдин мэдэгдсэн бол сарын дараагаар Засгийн газар ёслол гүйцэтгэхийг хүлээж авахгүйгээ дахин нотолсон аж.

Гэвч хятад сайд шахсаар байсан тул 1916 оны 3-р сарын эхээр Засгийн газрын өмнөөс Б.Цэрэндорж дахин тайлбар хийж, 2 зүйлийн шалтаг заажээ. Юуны өмнө өргөмжлөл гардуулахаар ирэх дээд түшмэд, тэднийг дагалдагсдын тоо нэн олон (50-60 хүн-Н.Х) тул зочлох дайлахад хүндрэлтэй болох, хоёрдугаарт, Богд гэгээний биеийн байдал сайнгүй учир хүнд хүчир ёслолыг гүйцэтгэж чадахгүй хэмээн цааргалжээ. Харилцан хэлэлцсэний эцэст Бээжингээс тусгай төлөөлөгч ирүүлэхгүйгээр, гагц Чен Лу-гаар гүйцэтгүүлэхээр болгож чаджээ (3.94-95). Чингэж шийдсэнийг Монголын талаас хийсэн амжилттай алхам гэж үзэлтэй. Ерөөс ДИУ-ын Ерөнхийлөгчийн шагналыг хүлээж авахаас цааргалсаны гол учир нь Богд Жибзундамба олон монголчуудаар хүлээн зөвшөөрөгдөж хаанд өргөмжлөгдсөнийгөө сануулсаар байсан хэрэг юм. Тийм ч учраас аливаа хэргийг Монгол улсын нэрээр хэвээр явуулж, оны цолоо хэрэглэсээр байсан билээ.

Түүнчлэн Хүрээнд суухаар ирсэн Чен Лу-г монгол сайдууд үл тоомсорлон удал хүлээлгэсэн ба дараа жил нь түүний оронд томилогдсон Вэнь Юн гэгчийг Өвөр Монголд Гаанжуур гэгээнийг хорооход оролцсон гэдгээр шалтаглан Монголын Гадаад яам хүлээж авахаас татгалзжээ. Улмаар Думдад улс Германд дайн зарласан үед Хүрээний цахилгаан мэдээний хороогоор дамжих мэдээг хянах гэсэн хятад сайдын шаардлагыг хүлээж авсангүй. Монголын засгийн газар боломжийн бүх аргаар хятадын оролцоог эсэргүүцэж, эс бүтсэн тохиолдолд үйл ажиллагааг сааруулахыг хичээж байв.

Үүний сацуу Монголын тал Оростой харилцаагаа хэвээр үргэлжлүүлж, элчин харилцааны асуудалд бие даасан шийдвэр гаргаж байсныг 1916 оны хавар Хиагт хотноо Оросын дэд консулын газар нээх явдлыг Монголын Засгийн газар ДИУ-аас асуулгүйгээр зөвшөөрсөн, Оросоос Хүрээн дэхь консулын газрыг Ерөнхий консулын газар болгосоны дараагаар хүрэлцэн ирсэн А.А. Орловыг Богд хаанд бараалхуулж, итгэмжлэх жуух бичгийг нь Гадаад яам хүлээн авсан явдлууд илтгэнэ. Цэргийн салбар дахь хамтын ажиллагаа үргэлжилж, орос сургагчдаар монгол цэргийг сурган боловсруулах гэрээг 1916-1918 онд дахин байгуулсан (4.15-17) төдийгүй 1917 онд хятад цэргийн эсрэг байлдаанд оросын сургагчдаас оролцуулсан байна (5.48-49). Энэ бүхэн нь монголчууд харьцангуй чөлөөтэй хөдөлж чадаж байсны гэрч бөгөөд С.Г. Лузяниний тэмдэглэсэнээр "...Гадаад Монголын бие даах боломж төвшинг илтгэн харуулсан хэрэг" (6.69) мөн.

Гэвч тус орны эргэн тойрон эхэлсэн үйл явдлууд Автономит Монголын байдлыг өөрчилсөн юм. Оросод хаант засаг унасан үеэс Бээжин Оросын үйл явдлыг анхааралтайгаар ажиглан, тэр нь автономит Монголд хэрхэн нөлөөлөхийг тооцоолж, тааламжтай цаг ирэхэд үйл ажиллагаа идэвхижүүлэхэд бэлэн байв.

ДИУ-ын Засгийн эрхийг барьж байсан, Японы талыг баримтлагч Аньфу бүлгийн генерал Дуань Цижуй 1917 оны 6-р сарын 20-ны өдөр Цэргийн яам, Ерөнхий штабт илгээсэн нууц захидалдаа "...Дотоодын эвдрэл, амжилтгүй дайн нь Орос орныг бүрмөсөн сульдаж, тэрбээр Халхын талаар анхаарах сөгөөгүй байна. Хятадын хувьд энэ хязгаарын (Монголыг хэлж байна-Н.Х) автономийг устгаж, түүнийг Хятадын бүгд найрамдах улсад

бүрмөсөн нэгтгэх арга хэмжээг авах таатай агшин ирж байна” (7.174) хэмээсэн нь Халхын талаар явуулах үйл ажиллагааг ил тодоор томъёолсон хэрэг байлаа.

Улмаар 1918 оны 3-р сарын 1-нд Думдад улсын Хурлын сонгуулийг явуулах тухай Ерөнхийлөгчийн хуульд Гадаад Монгол, Урианхайн хязгаар нь Хятадын “ердийн муж” хэмээн зарлагдаж, өөрсдийн төлөөлөгчдийг илгээх тухай заасан бол 10-р сард Хүрээн дэхь Хятадын Банк Монголын засгийн газрыг шахамдуулан байж, Монголын нутаг дэвсгэр дээр зөвхөн тус банкны цаасан мөнгийг хэрэглэх гэрээг байгуулж чаджээ. Энэ мэтээр Гадаад Монголын автономийг устгахад чиглэсэн алхмууд зугуухан хийгдэж эхлэв.

Энэ завсар шинэ тулгар байгуулагдсан ЗОУ их, бага улсуудын харилцааны шинэ хэв маягийг тогтоохыг зорьж, урьд хаант Орос ба Монголын хооронд байгуулсан бүхий л гэрээг цуцалсаны дотор Хиагтын гурван улсын гэрээ багтсанаар Гадаад Монголын автономит эрхийг хууль ёсоор баталгаажуулсан олон улсын гэрээ хүчин төгөлдөр бус болов. Тэр тусмаа ЗОУ нь Монголын орон зайд өөрөө орж ирээгүй байсан явдал Думдад улсын зүгээс Монголын асуудлыг дангаар шийдвэрлэх элдвийн аргыг хайхад бүр ч дөгөө өгчээ.

1917 оны тавдугаар сард Чен Лу Хүрээнээс буцаж, оронд нь Хүрээний бүгдийг хамгаалах газрын дэд сайд, Улиастайн сайдаар ажиллаж байсан Монголын хэрэг явдлыг сайтар мэдэх Чен И томилогдов. Тэрбээр Сибирь, Өвөр Байгаль дахь үймээн самууны улмаас Монголын хил хязгаар түгшүүртэй болж ирсэн үед Оросын аюулын тухай ярьж эхэлсэн бөгөөд 1918 оны 2-р сарын 14-нд “...Оросоос хамгаалж чадах эсэхийг Монголын эрх баригчдаас тулгаж асуух, тэднээр оросын үймээн дарагдтал хятад улс цэрэг илгээж суулгах хүсэлтийг гаргуулах, хэрэвзээ тохиролцох аваас цэрэг илгээх асуудлыг бэлтгэх” зааврыг ГЯЯ-аасаа авчээ (8.39). Чен И асуудлыг тэр даруй хөндсөн ч Монголын Засгийн газар Хиагтын гэрээгээр тогтоосоныг баримталсаар байсан тул арга буюу цэрэг илгээх шаардлагагүй хэмээн Бээжинд мэдэгдэв.

Гэвч удалгүй хил залгаа Троицкосавскт зөвлөлт засаг тогтож, цагаантнууд Монголд нэвтрэх болсон, атаман Семенов Манжуураас Зөвлөлтийн нутагт цөмөрсөн зэрэг нь нөхцөл байдлыг шинжин суусан Хятадын талд далим болж, 1918 оны 4-р сараас Хүрээний сайд Чен И хятад цэрэг ирүүлэх зөвшөөрлийг Монголын Засгийн газраас гаргуулахаар хөөцөлдөж эхэлжээ. Энэ тухай мэдсэн Оросын консул А.А. Орлов: Гадаад Монголд хятад цэргийг оруулах нь цөөхөн тооны хамгаалах цэргийг байлгахыг заасан Хиагтын гэрээний 7-р зүйлийг зөрчиж буйг Б.Цэрэндорж, Чен И нарт албан ёсоор мэдэгдсэнд хятад сайд дараах утгатай хариуг өгчээ. Тэрбээр “...Аливаа гэрээ нь тайван цагт хүчинтэй байдаг ч үймээн самуунтай үед үйлчлэх эрх чөлөөгөө хязгаарлаж чаддаггүй. Гурван улсын гэрээ нь гагц Гадаад Монголын тухай хэрэг явдлын хүрээнд л хамаатай, харин энэ [цэрэг оруулах] арга хэмжээ бол зөвхөн гадаад нөхцөл байдлаас үүдэлтэй бөгөөд гэрээг хязгаарлаагүй” (7.176) гэжээ. Өөрөөр хэлбэл, хаант Орос үгүй болсон үед Чен И А.А.Орловыг төдийлэн тоож үзээгүй бөгөөд Монголд цэрэг оруулах нь ДИУ-ын эрх хэмжээний асуудал гэсэн санааг илэрхийлсэн гэж болно. Харин “...тухайн асуудал нь Хятад, Монгол хоёрын шийдэх хэрэг бус бөгөөд, ерөөс түүнийг зөвшөөрөхгүй” гэсэн мэдэгдлийг Монголын ГЯЯ-ны сайд Б.Цэрэндоржоос авчээ.

Гэхдээ Монголд хуучин хэвээр сууж, адмирал А.Колчакийн засгийн газрыг төлөөлж байсан Ерөнхий консул А.А.Орлов туйлбартай байж чадаагүйг тэмдэглэхгүй өнгөрч болохгүй. И.Я.Коростовецийн бичсэнээр өмнөх консул А.Я. Миллер нь “...хятадуудад найрсаг ханддаг байсан ч тэднээс Монголын автономит эрхийг зөрчих, Монголын дотоод хэрэгт хэтэрхий оролцох явдлыг өчүүхэн төдий ч гаргуулдаггүй байсан” (9.411) бол А.А.Орлов большевик хувьсгалын нөлөөнөөс айхдаа “хятадад хандан тусламж гүйх” сэтгэлгэнд дэм өгч байсан нь цаашдын үйл явдлаас тодорно. Түүнд Бээжин дэхь төлөөлөгч Н.А.Кудашев хүчин хавсарч, “Монголыг большевикуудаас хамгаалах” асуудлыг Хятадын засгийн газарт тавьж байсан (10.27-28) мэдээ бий.

Монголын Засгийн газар хятад цэрэг ирүүлэх саналыг эрс эсэргүүцсэн ч сул доройнхоо улмаас арга буюу Чен И-тэй хэлэлцэхэд хүрч, “...хятадын цэргийн нэг хороог Монголд оруулж, европын байлдааны хэрэг дуусч цагийн байдал түвшидсэн хойно гаргах”-аар 1918 оны 5-р сарын 26-нд тохиролцжээ. Тэр даруй Чен И “...Төвөөс цэрэг оруулж хамгаалалтыг хамтатган бататгавал болох эсэхийг асуухад Цэрэн анх удаа

зөвшөөрөв” хэмээн Засгийн газартаа мэдэгдсэн аж (8.40). Монголчууд тийнхүү тохиролцоход хүрсэн нь Оросын зүгээс Монголын хил хязгаарыг зөрчих болсоны шууд үр дагавар болохын хамт Хятадаас авах зээлийн асуудалтай мөн холбоотой байсныг тэмдэглэе.

Үүний дараагаар 7^р сарын 30^{нд} Хятадын Хуурай замын цэргийн яамнаас Хөх хотын дивизийн дарга Го Цай таны захирсан 2 хороог Нийслэл хүрээнд оруулах шийдвэр гарч, 11^р сарын эцэс гэхэд 700 хүнтэй морьт цэрэг ирсэн гэж хятадын түүхч Чен Цунзо бичжээ (11.136). Цэргийн тооны тухайд харилцан адилгүй мэдээ байдаг ч тохиролцсон ёсоор оруулах нэг хороо цэрэг хоёр болсоны учир нь хятадууд морьт ба явган цэргийн тоо адилгүй байдгийг ашигласантай холбоотой. Үүний дүнд 1 хороо явган цэрэг гэдэг нэрийн дор морин цэргийн 2 хороог оруулахаар болсон бөгөөд судлаач М.Ариунсайханы тооцоолсоноор Го Цай таны цэрэг нь үндсэндээ морьт цэргийн 4 хороотой тэнцэх буюу 800 орчим хүнтэй байсан аж (12.42). 1918 оны 9^р сарын эхээр хятад цэргийн түрүү анги Хүрээнд орж ирсэнээр Монголыг Хятадад хавсарган нэгтгэх зүгт эхний алхам хийгдэв.

Түүнчлэн Ховд, Улиастай, Хиагтын хятад түшмэдийг хамгаалах цэргийн тоог тогтоосон хэмжээнээс хоёр дахин нэмэгдүүлсэнээр Гурван улсын гэрээгээр тогтоогдсон хятад цэргийн тооны хязгаар эвдэгдсэн бөгөөд тухайн жишгийг “... цаашид аливаа хэрэг гарахад хэрэглэж болох” тухай Чен И Засгийн газартаа мэдэгдэж байв. Үүний хамт тэрбээр “... байдал тогтвортой болмогц цэргийг татаж үнэнч байдлаа харуулахаас өөр аргагүй. Хэрэв цэргийг байнга байрлуулахыг хүсвээс Төв Засгийн газар хүч зузаарсан хойно оросуудтай хэлэлцэн гэрээг засварлах хэрэгтэй, өнөө цагт энэ хэргийг гүйцээх хэцүү” (8.39-40) гэх зэргээр давхар учирлахаа мартсангүй. Энэ нь түүний өгөөмөр зангийн илрэл бус, харин автономит засгаа авч үлдэхийн тулд монголчууд бололцооны бүхий л аргаар чармайж байсан тул автономийг цуцлах ДИУ-ын зорилго нилээд цаг хугацааг эзэлж, бас ч үгүй янз бүрийн аргыг дэс дараалан хэрэглэхэд хүрч байсны гэрч болно.

Монголчуудтай аядуу зөөлөн аргаар харилцаж эрхэндээ оруулах гэсэн зальжин бодлогыг Чен И баримтлах болж, түүнийг нь Хятадын шинэ Засгийн газрын ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайдаар томилогдсон Чен Лу дэмжжээ. Тэрхүү аядуу зөөлөн бодлого гэдэг нь Хятад, Монголын хооронд хэлэлцээр хийх явдал байсан бөгөөд 1919 он болоход Хиагтын гэрээг нэгэнт эвдэгдсэн хэмээн үзсэн ДИУ-ны ГЯЯ “... Оросын худалдааны давуу эрхийг Хятадад шилжүүлэх, цэрэг байрлуулах хязгаарыг арилгах, Хятадын ёс жаяг, зэрэг дэв, он тоолол зэргийг сэргээх замаар Хятад, Монголын хамаарлыг бэхжүүлэх, эртний адилаар Монголтой ойртох явдлыг тусгасан” шинэ хэлэлцээрийг Ар Монголтой байгуулах зааварчлагыг Чен И-д өгчээ. Өөрөөр хэлбэл, Монголын хэрэг явдалд саад болж байсан Хиагтын 3 улсын гэрээг цуцлах санаа чухам энэ үеэс илэрхий болсон байна.

Гэвч нөхцөл байдал таатай бус байсан тул монголчуудын дүргүйцлийг хүргэхээс эмээсэн Хүрээний сайд Чен И алхам алхмаар үндсэн зорилгодоо хүрэхээр шийджээ. Тэрбээр Ар Монголын гүйцэтгэх эрх мэдлийг Бээжинд харъяалуулах, ГЯЯ-ыг татан буулгах, Монголын Засгийн газарт ордог хятад иргэдийн татварыг өөрсдөө хураан авч, харин хэмжээний мөнгийг Монголд “өөрийгөө засаглах зардал” болгон олгож байх, Богдод Далай ламын адил насны цалин 10000-ыг өгөх буюу арай багаар тогтоох, Богдын цол хэргэм зэргийг Хятад, Монголын хурлаар тогтоох, монголчуудыг төлөөлөгчөөр сонгох, ДИУ-ын албан тушаалд томилохыг зөвшөөрөх зэргээр Хятадын бүрэн эрхийг өргөжүүлэх” (8.40) саналыг ГЯЯ-ндаа илгээхийн хамт цэрэг ирүүлэх явдлыг зогсоосонгүй.

Монголын Засгийн газар “Оросын хил дээр байдал тайван болсон” тул цэрэг илгээх явдлыг зогсоохыг удаа дараа мэдэгдсэн боловч “цэргийг буцаах явдлыг даана” хэмээсэн амлалтаа Чен И биелүүлээгүй бөгөөд цааш цаашдаа түүний зорилго хэрэгжихэд нэмэр болсон үйл явдлууд дараалан гарах болжээ. Сибирьт зөвлөлт засаг унасанаар Монгол нутаг дүрвэгсдийн орогнох газар болж, мөн “Нармай Монголын хөдөлгөөн” гэгч зүйл гарч ирэв.

Нийт монгол угсаатны нэгдсэн улсыг байгуулахаар зорьсон буриад, барга, өвөрмонголчууд тухайн хэрэгтээ Халх Монголыг оролцуулахыг чармайж, эс бүтсэн тохиолдолд цэргийн хүч хэрэглэхээр сүрдүүлж байв. Энэ тухай товчхон өгүүлбээс: Нармай Монголын хөдөлгөөнийг Монголын засгийн газар дэмжээгүй бөгөөд Даурын хуралд төлөөлөгчөө оролцуулсангүй, зөвхөн элч зарсанаар хязгаарлажээ. Энэ тухай тус

хөдөлгөөний идэвхитэй зүтгэлтнүүдийн нэг Э.Д.Ринчиногийн бичсэнээр "... хэрвээ тэдний байгуулсан нийт Монголын улсыг Версалын бага хурлаар баталж, Англи, Америк дэмжсэн тохиолдолд нэгдэхээ амласан" захидал хүргүүлсэн аж (13.231).

Энэ нь хэд хэдэн зүйлийн учир шалтгаантай байлаа. Юуны өмнө Монголын Засгийн газар Хиагтын гэрээгээр хүлээсэн үүргээ чандлан сахиж элдэв зүйлийн явдалд оролцохоос ангид байхыг хичээжээ. Мэдээжийн хэрэг, тухайн үед Халх Монгол нь нийт монголчуудаа нэгтгэх үзэл санаагаа тээсээр байсан ч тэр тухай бодох цаг үе биш байв. Тэгээд ч 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үед явуулсан түүний бодлого үйл ажиллагаа хөрш орнуудын улс төрийн хавчилт шахалтын улмаас хэрхэн тасалдан саарч, улмаар Хиагтын гэрээний үр дүнд дүргүйцсэн өвөрмонголчууд нутаг буцан, Бавуужав нарын зарим нэг нь бослого гаргасанаар тус орны гадаад харилцаанд таагүй үр дагавар бий болгосоныг санахаас аргагүй байв.

Нөгөөтэйгүүр Монгол дахь Оросын нөлөө суларсаны дараагаар ихэд идэвхижсэн буриадуудын үйл ажиллагааг шашин төрийг хослон барьсан Монголын эрх баригчид үл таашаан, тэднээс сэрэмжлэх болсон нь Нармай Монголын хөдөлгөөнд болгоомжтой хандахад хүргэсэн бас нэг шалтгаан болно. Тэрхүү таагүй байдал нь нийгмийг ардчилах, оршин буй байгууллыг халах үзэл санааг буриадын зүтгэлтнүүд дэлгэрүүлж, түүнийг Монголын нийгмийн тэргүүний хэсгийнхэн дэмжих болсоноос үүдэлтэй хэмээн үзэж болох юм.

Өөр нэгэн зүйл бол нийт Монголын хөдөлгөөнд Колчакийн Засгийн газар таагүй хандаж байсан явдал юм. Тэрбээр уг хөдөлгөөнийг "гэрээгээр тогтоосон олон улсын харилцааг зөрчсөн хэрэг" хэмээн үзэж, тэр тухайгаа Омск дахь Англи, Францын төлөөлөгчдөд албан ёсоор мэдэгдэж байжээ. Энэ бүхэн нь Нармай Монголын хөдөлгөөнд хандах халх монголчуудын байр суурийг тодорхойлсон бөгөөд Халх, Дөрвөдийн 6 аймгийн ноёд бүгд зөвлөлдөн хэлэлцсэний эцэст "монгол овогтон нэгдэх нь гурван этгээдийн гэрээнд харштай тул үл зөвшөөрөх" өөр шийдвэрлэжээ.

Нармай Монголын хөдөлгөөний талаар гарсан сүүлийн үеийн ном бүтээлүүдэд Чита ба Хүрээний хоорондын харилцааны дүр төрх, үйл явдлын өрнөл төгсгөлийг тодотгох шинэ мэдээ баримтыг судалгааны эргэлтэд оруулсаны дүнд зарим нэгэн асуудлыг илүү дэлгэрэнгүй харуулах боломж нээгдэж байна. Чухам тийм асуудлын нэг нь 1919 оны 6-р сард Ц.Е.Цыдыпов, хурандаа Левицкий нарын Даурын төлөөлөгчид Хүрээнд ирсэн явдал мөн. Тэд Читийн хурлын зорилгыг таниулах, эн түрүүнд VIII Богд Жибзундамбын удирдлагын доор нийт Монголын Засгийн газар байгуулах асуудлыг товойлгон тавих үүрэг хүлээсэн бөгөөд нэн даруй Гадаад яамны сайд Б.Цэрэндоржтой уулзан хэрэг учрыг тодорхой илтгэсэн ажээ. Уулзалтын үед, нэн ялангуяа Ц.Е.Цыдыповтой ганцаарчлан уулзах үед монгол сайд Читийн хэрэг явдлын талаар ихээхэн сонирхож, түүнд Өвөр Монгол, Баргын ноёд хэрхэн хандаж байгааг асууж байсан ч Монголоос төлөөлөгч илгээх асуудал тавигдахад Богд хааны таалал мэднэ хэмээн тодорхой хариу өгсөнгүй. Үүний хамт тэдний яриа хэлэлцээрийн тухай хятад сайд мэдэхээс сэрэмжилж байжээ.

Анх уулзан хэлэлцсэнээс хойш тав, зургаа хоног өнгөрсөн ч Богд хаан тэднийг хүлээж аваагүй бөгөөд ГЯЯ-ны сайд Б.Цэрэндоржоос Монголын засгийн газар Читийн хуралд төлөөлөгч илгээхээс түдгэлзэж байгааг мэдэгдэв (14.32). Үүний шалтгаан нь Гадаад Монголын автономит туйлын эгзэгтэй нөхцөлд оршиж байсан нөхцөлд олсон бүхнээ алдахад хүрч болох учраас өөрөөр хандах боломж, сонголт байгаагүйтэй холбоотой. Төлөөлөгчид 6-р сарын 17-нд буцжээ.

Үүний дараагаар 1919 оны 8-р сарын 4-нд² (6 сарын шинийн 8) Нийслэл Хүрээний Хамба номун хан, дэд хамба Эрдэнэ шанзав Да лам нарын нэрээр гарсан бичигт "... бүгдээр зөвлөлдөж мэхийн хянаваас манай гадаад монголчууд Орос, Дундад Иргэн улс лугаа санаа нийлэлдэж, автономит Гадаад Монгол улс болж нэгэнт гэрээ бичиг тогтоосоноос хойш манай гурван этгээд гэрээ бичгийг дагаж тус тус дор нам гүм аж төрсөөр буй атал одоо манай монголчууд гэнэтэд санаа өөрчилж, гурван этгээдийн тогтоосон гэрээг шууд эвдэж, санаа өөрчлөн зайлан гарч, үнэн худал нь мэдэгдэхгүй үг

² Эх бичигтээ 6 сарын 8 гэсэн нь илүү 5-р сартай 1919 оны хувьд аргын тооллын дээрхи өдөртэй дүйцэж байгаа болно.

бичиг тархаасаныг дагалдаж тэд нар лугаа нийлж, гагцаар тогтносон бүрэн эрхтэй тусгаар улс болох аваас манай монголчууд хойч өдөр гэрээ тогтоосон Орос, Дундад Иргэн улс хоёр улс лугаа үүрдэд найрамдалгүй болж, цаг үргэлжид сэрэмжлэн тэдний хоёр этгээд лүгээ зах нийлэх нутгийн хязгаарыг сэргийлэх зэрэг элдэв будлиан чирэгдэл маш их болж гүйцэшгүйд хүрч үнэхээр бэрхтэй зүйл үлэмж болох төдийгүй энэ мэт тогтоосон гэрээг эвдэж санаа өөрчилсөн этгээдэд олон улсын ёс дүрэм дор ямар зүйлийн харштай хэмээн ял ногдуулахыг олж мэдэхгүй ба бас бусад олон улс дор ямагт итгэмжгүй болж, нэр сүрийг алдаж буруушаагдах зүйл байх ажгуу" (15.) хэмээн зааж, Нармай Монголын хэрэгт оролцохгүй гэдгээ бат нотоор мэдэгдсэн байна. Түүгээр ч үл барам Даурын зүгээс цэрэглэн халдаж ирсэн тохиолдолд зөвхөн 4 аймаг төдийгүй Их Шавь, дагаар орсон хошуудыг дайчлан нийтийн хүчээр эсэргүүцэх, гаднаас хамгаалал тусламж үл горилохоор тогтжээ (16.170). Ер нь Монголын эрх баригчид "...буриад хүн нар Дотоод Монголын муу хулгай нартай сүлбэлдэн удаа дараа хүн зарж Хүрээнд ирүүлэн хамт нийлэлдэн гагцаар тогтносон улс болтугай хэмээн хатгаж өдөөсөн" гэж хэмээн үзэж, тэднийг "ухваргүй ардууд" гэж нэрлэсэн байдаг (21.).

Халх Монголын энэхүү байр суурь нь Семеновын зүгээс цэргийн хүчээр халдан довтлоно хэмээн сүрдүүлэхэд хүргэж, хүчин хомсдсон Халхын эрх баригчид хятадад хандаж, тэндээс цэрэг томилон гаргаж болж, цэргийн түшмэд арван хэдэн хүн ирж, газар орны байдалтай танилцан монголын эрх баригчидтай уулзсан зэрэг үйл явдлууд дараалан болжээ. Бээжингийн цэргийн эрхтнүүд Монголд цэрэг нэмэн оруулах асуудлыг ил тодоор тавих болов.

Орос, Монголын харилцааны түүхийн талаар томоохон бүтээл туурвисан эрдэмтэн Е.А. Белов 1919 оны 4-р сарын 2-нд Бээжин дэхь Оросын төлөөлөгч Н.А.Кудашев Хятадын Гадаад яаманд хандан Гадаад Монголд цэрэг илгээх гэж байгааг эсэргүүцсэнд: "... Гадаад Монгол нь Хятадын нутгийн хэсэг тул тэнд хэв журам сахиулах, амар тайван байлгах асуудлыг хайхрахгүй байх ёсгүй бөгөөд тийш нь цэрэг илгээх нь Хятадын Засгийн газрын "оновчтой арга хэмжээ болно" (7.179) гэсэн хариуг өгсөн гэж өгүүлсэнээс цэрэг оруулахаар нэгэнт шийдчихсэн нь ил харагдана. Чингэж Нармай Монголын хөдөлгөөн Монгол дахь хэрэг явдлын өрнөлтөд сөрөг үр дагаврыг авчирчээ. Энэ тухай японы эрдэмтэн Х.Футики "... уг хөдөлгөөн богино насалсан ч үр дагавар нь Гадаад Монголын автономийг хятадын зүгээс устгах явдлыг түргэтгэсэн" (17а) гэсэн бол Икома Масанори "...Богд хаан Гадаад Монголын ноёдыг хуралдуулж, Семёновын үйл ажиллагааг дэмжихгүй байхаар тогтсоны хариуд Семенов Халх Монголыг довтлоно хэмээн сүрдүүлсэнийг Бээжингийн засгийн газар далимдуулан, Гадаад Монголын автономийг устгасан" (176.190-191) хэмээн дүгнэсэнийг дэмжих ёстой.

Семёновын сүрдүүлэг хятадуудад олз болохын хамт Монголын асуудлыг өөрийн хүслээр шийдэх гэсэн тэдний замд саад тээг болж мэдэх, түгшүүр төрүүлсэн зүйл дахин гарч ирсэн нь гадаадын интервенцийн аюулыг арилгаж, хүч чадлаа харуулсан Улаан армийн Сибирь, Өвөр Байгалийн чиглэлд хийсэн давшилтын дүнд зөвлөлт засаг дахин тогтсон явдал байлаа. Чухам үүнээс сэрэмжилсэн хятад цэргийнхэн Монголын өөртөө засах эрхийг устгахаар яаравчлав.

Эцэст, Хятадын цэргийнхний үйл ажиллагаа идэвхижихэд Монголын дотоод байдал ч дөгөө өгөхөөр байлаа. Ихэс дээдэс өвөр зуураа хар шар хэмээн зөрчилдөж, төрийн өмнө хүлээсэн үүргээ умартан эрх дарх, мэдэл хүчний төлөө өрсөлдөх болсоны улмаас засаглалын хямрал нүүрлэсэн байв. Шавь хэмээх нэрээр олныг хурааж, эрх мэдэл нь чангарсан хутагт хувилгаадаас авахуулаад хаалгач донир хүртэл хошуудын эрх баригчдыг доромжлох нь хэрээс хэтэрч, зарлиг лүндэнгээр ноёдын хэргэм зэргийг эвдэж байсны улмаас элдэв зүйлийн дарлагдлаас ангижрахын тулд угсаатны доторхи зарим нэгнийг хятадын зүг хандах санаа төрүүлсэнийг түүхч Магсар хурц Засагт хан аймгийн Ачит чин ван Гончигдамбын үйлдлээр жишээлэн болгосон байдаг (3.139). Түүнчлэн Оросын консул А.А.Орлов 1918 оны зунаас Монголын угсаатан ноёдын дунд Монголын автономитийг устгахыг дэмжигсэд гарч, тэрхүү санаа бодол Ерөнхий сайд Т.Намнансүрэнг нас барсаны дараагаар хүчтэй болсон тухай Н.А.Кудашевт мэдээлж байжээ (7.179). Үнэхээр Монголын тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч, улс төрийн томоохон зүтгэлтэн, шинэчлэлийг дэмжигч ерөнхий сайд Т.Намнансүрэн 1919 оны хавар нас барж,

оронд нь хятадын талыг баримтлагч шанзудба Бадамдорж тохоогдсон нь автономитийг устгасан хожмын хэрэгт нөлөөлсөнийг үгүйсгэх ёсгүй.

Монгол дахь засаглалын хямралыг овжноор ашиглахыг хичээсэн Чен И Монголын Гадаад яамны сайд Б.Цэрэндоржид "Дундад, Монгол угаас нэгэн гэр улс" хэмээн итгүүлэхийг оролдон ятгаж, улмаар эрх баригчид зөвлөлдөн автономит засгаа өөсдөө гуйн устгах бичиг гаргаж өгөхийг шаардах болжээ.

Тухайн цагт үйл явдал хэрхэн өрнөсөн талаар түүхч Н.Магсаржав, Л.Дэндэв нар тодорхой бичиглэн үлдээжээ. Тэдний бичсэнээр ерөнхий сайд Бадамдорж, Гадаад яамны сайд Цэрэндорж нар "цагийн байдал автономит засгийг устгахад хүргэнэ" гэж үзэж байсан тул Богд хаанд айлтгасан, Богдоос "автономит засгийг устгаваас урьдах Чин улсын үеэс илүү ямар эрх олгох"ыг тодорхойлон мэдэхийг зарлиг болгосон, тэр тухай Бадамдорж Чен И-д уламжилсан үйл явдлууд дараалан болж, Гадаад Монголын автономит эрхийг устгасны дараах Монголын эрх мэдлийг тодорхойлох гэрээ бичгийн төслийг бэлтгэж эхэлжээ. Энэ хэрэг Чен И, Бадамдорж, Цэрэндорж нарын дунд голчлон өрнөж, хятад сайд Монголын ерөнхий сайдын гэрт ирж, урьд Цэрэндоржид өгсөн хятад бичгийг өөрийн биеэр орчуулан 50 гаруй зүйл бүхий гэрээ бичгийг анхлан зохиожээ (18).

Монголчуудад олгох эрхийн хувьд Чен И-гийн бичиг нь Манж Чин улсын үеийнхээс илүүгээр заасан зүйлгүй, гагц Богдын цолыг Да жунтангаас өргөмжилнэ гэсэн тул олны санаа хийгээд Богдод үл таалагдана гэж эмээсэн ерөнхий сайд Бадамдорж нэмэлт оруулахаар тохиролцон, 15¹⁹, 22, 28³⁰, 40 дүгээр зүйлүүдэд Богд хаан, Эх дагина, Их Шавь, хутагт хувилгаад, шанзудба нарын эрх ямба, хурал номын зардал, цалин пүнлүүг нэмж бичжээ.

Монголын ерөнхий сайдын оруулгад улс төрийн талаар нэмсэн, Чен И-гийн бичсэнээс хассан зүйл байхгүй бөгөөд ердөө л төрийн удирдлагад гарсан шашны төлөөлөгчийн хувиар ашиг тусаа хамгаалсанаас цаашгүй үлдсэн ажээ. Үүнээс үзвэл Чен И нь Гадаад Монголын автономит засгийг устгах үндсийг тавьсан этгээд мөн бөгөөд түүнд Монголын ерөнхий сайд Бадамдорж хүчин хавсарсанаар (10 зүйлийн нэмэлтийг хийсэн Н.Х.) "Гадаад Монголын өөртөө засах эрхийг устгасны хойно Дундад засгийн газраас Гадаад Монголыг хүндэтгэх ба жич хойчийг сайжруулах хууль зүйл" буюу түүхэнд "Чен И-ийн 64 зүйл гэрээ" гэж товчхон нэрлэх бичиг буй болов. Тиймээс Бадамдорж Чен И-тэй хуйвалдсан гэсэн түүхч Л.Дэндэвийн үзлийг дэмжихээс өөр аргагүй.

Бичигт Гадаад Монгол ДИУ-ын улсын тусгай нэгэн газар болж түүний эрх, хууль хэмжээг бүрэн дагахыг зааж, Хиагтын Гурван улсын гэрээг хятадын тал дангаар цуцлан, Монгол ба хаант Оросын хооронд байгуулсан гэрээ бичгүүдийг ч хүчингүй болгохоор тусчээ. Энэ нь Монголын тусгаар байдлыг бүрэн устгана гэсэн үг байсан бөгөөд бусад зүйл заалтууд нэгэн адил хамаарагдана. Тухайлбал, Монголын хязгаарыг сэргийлэх цэргийг ДИУ-аас суулган түүний зардал хэрэгслийг Монголоос авах татвараас гаргуулах, тэр зорилгоор албан сүрэг байгуулах (31³⁵-р зүйл), дотоод газрын иргэдийн газар авах, эзэмших, хагалбарлах эрхийг цөм хятад сайдын газрууд эрхлэхээр заасан нь Монголын аймаг, хошууны эрх баригчдыг засаглах эрхээс нь ангижруулсан хэрэг мөн. Түүнчлэн Монголын хязгаарын доторхи хөрөнгийг бүртгэн, орлогыг тодорхойлох, татварыг хэмжээг тогтооход хятад сайдын хяналт бий болгох явдал мөн багтжээ.

Гадаад Монголын засгийн газраас өөрөө гуйн эрхийг устгасаны дараагаар хийгдэх зүйлийг дэлгэрэнгүй заасны дотор Монголоос хаант Орост төлөх үлдэгдэл өр болох 320 илүү түм рублийг Монголын Сангийн яамнаа үржүүлсэн мөнгөнөөс төлүүлэх асуудал ч орсон байв. Үүний хамт гэрээ бичгийг монголчуудаар хүлээлгэхийн тулд хөрөнгөтний ардчилсан өөрчлөлтийн шинжтэй зарим зүйлүүдийг тусгахаа мартаагүй бөгөөд тухайлбал, Богд Жибзундамба тэргүүтэй ноёд дээдэс, хутагт хувилгаад, аймаг хошуудын эрх баригчдын эрх мэдэл, цалин пүнлүү зэрэг асуудлыг нилээд олон зүйлд тодорхой заасан нь ихэс дээдсийг өөртөө татах гэсэн башир арга юм.

Гэрээний төслийг ерөнхий сайд Бадамдорж болон Гадаад яамны сайд Цэрэндорж нар зөвшөөрөх байдлаар хэлэлцсэн нь Чен И-ийн үйл ажиллагааг идэвхижүүлж, тэрбээр

* Энэхүү бичгийн анхны эх ноорог болон засвар хийсэн хувиуд эдүгээ манай улсын Үндэсний төв архивт хадгалагдаж байна.

өргөх бичгийг тасралтгүй шаардсан ч 64 зүйлийн гэрээг Богд хаан хүлээж авсангүй. Харин Бадамдорж 1919 оны 7-р сард Улсын Дээд, Доод хурлыг хамтран хуралдуулсанд "...Доод хурлаас дараа хянан зөвлөлдөж, хорыг шүүмжлэн хэлэлцэхээр буцааж, харин Дээд хурлаас зөвшөөрөх аястай байсан" хэмээн Магсар хурц бичсэн байдаг. Гэвч эцсийн шийдэлд хүрээгүй бөгөөд энэ завсар Чен И, Бадамдорж нарын үйл ажиллагаа олон түмэнд мэдэгдэж, тэднийг шүүмжилсэн, эсэргүүцсэн бичгийг Хүрээний хүрдэн дор наалдуулах зэргээр санаа бодлоо илэрхийлэх байв.

Богд хааны зүгээс Чен И-г Монголын эрх баригчдыг лугаа нам нийлж, засгийн эрхийг устгахаар болов хэмээн буруушааж, түүний талаар ДИУ-ын Ерөнхийлөгчид мэдэгдэн "хуучин хэвээр тогтнуулах"-ыг хүсч элч заржээ. Тухайн үед Бээжинд очоод байсан жонон ван Цогбадрахаас Да жунтанд захидал илгээвэл болох талаар мэдэгдсэн даруй гүн Гомбыг илгээжээ. Гэвч тэрбээр "...тус засгийн эрх баригчид хятадын төлөөлөгч Чен И лүгээ хуйвалдаж, Монголын засгийг устгахыг идэвхийлэн бүхий хэрэгг олон монголчууд дурлахгүй" гэсэн үг бүхий захидлыг нэвтрүүлж чадсангүй.

Үүний дараагаар Богд хааны зарсан Жалханз хутагт ДИУ-ын их ерөнхийлөгчтэй нүүр тулан уулзаж, "...хутагтын санаа автономит эрхээ хэвээр хадгалж болмуй" гэсэн үг зөвшөөрлийг авсан ч буцаж амжаагүй байхад үйл явдал нэн түргэнээр өрнөж, Бээжин Монгол орныг цэргийн хүчээр түрэмгийлэн эзлэхээр бэлтгэж, цэргийн хүчийг нэмэн илгээсээр байв. Хүрээний сайд Чен И-ийн удаа дараагийн хүсэлтээр ДИУ-ын Баруун хойт хязгаарын цэргийн III дивизийн явган цэргийг хөнгөн зэвсэгтэйгээр, автомашинаар тээвэрлэн Монголд оруулсанаас нэг хороо цэрэг Монголын нийслэлд байрлах болж, Хүрээний цэргийн захирагчаар дивизийн дарга Чү Чиү сян, ерөнхий зөвлөлийн дарга Ли Рүжан нар томилогдсон байв(12.44). Өгүүлэн буй үед Монголд арваад мянган цэрэг ирж Нийслэл Хүрээ, Улиастай, Ховд, Хиагт зэрэг чухал боомт газруудад байрласан мэдээ буй(19.4).

Чен И-сайдн дипломат оролдлого амжилт олохгүй байсан нь Хятадын засгийн эрхэнд гарсан аньфу намын эрхтнүүдийн зүгээс Монголын асуудалд хатуу ширүүнээр хандах явдлыг буй болгож, тэдний төлөөлөгч Сюй Шу жан Монголыг тохинуулахаар томилогдов. Дуань Чижуйн байгуулсан "Баруун хойт хязгаарын хэргийг сүвэгчлэн сайжруулах сайдын яам" гэгчийн сайд бөгөөд Баруун хойт хязгаарын сэргийлэх цэргийн ерөнхий захирал, генерал Сюй Шу жан 1919 оны 11 сарын эхээр* цэргийг байцаах нэрээр Нийслэл Хүрээнд хүрч ирэв. Тэрбээр ирсэн даруй цэргийн туг тахих ёслолыг үйлдэж, ерөнхий сайд бөгөөд Дотоод яамны тэргүүн сайд Бадамдорж тэргүүтэй хорь гаруй ноёд лам нартай уулзан, хятад пүүсийн газруудад найр наадам хийж, бэлэг сэлт бололцжээ.

Шаргачин хонин жилийн намрын сүүл сарын 24-25 буюу аргын тооллын 11-р сарын 16-17-ны тэр л өдрүүдэд үйл явдал хоромхон зуур өрнөж, Сүй шу жан Гадаад Монголын автономийг устгахаар төлөвлөж буй хэрэг явдал нь түүний тушаалын хэрэг болохыг сануулан гуйн өргөх бичгийг гаргаж өгөхийг шаардав. Бадамдоржоос "их, бага олны санаа нэгдээгүй" тул хараахан төгөлдөр болоогүй хэмээн цааргалсан ч хятад генерал "...нэгэнт тогтсон хэрэг явдал тул Гадаад Монголыг Думдад улсад нийлүүлж газар орныг бүрэн бүтэн болгон авна" (3.156) хэмээн тулгажээ. Чингэхдээ, өмнөх сайд Чен И-ийн адилаар автономит засгийг нь устгах хүсэлтийг Монголын ихэс ноёдоор өөрсдөөр нь гаргуулахыг зорьж, элдвээр аашилсанаас Богд, ерөнхий сайд нартай ял хэлэлцэнэ хэмээн сүрдүүлж, 24-ны орой тэдний гэр орныг тойруулан цэрэг жагсаан муу сүрийг үзүүлсэн нь олон түмэнд тэр дорхноо ил болов. Маргааш өглөө нь ерөнхий сайд Бадамдорж Богд хаанд бараалхан нөхцөл байдлыг илтгэн гуйн өргөх бичгийг гаргаж өгөхөөс аргагүйд хүрсэнээ илтгэн зөвшөөрлийг олжээ. Үүний дараагаар Сүй шу жан цэргийг буулгасан ба өөрийн биеэр зохиосон бичгийг Монголын засгийн газарт өгч, мөн өдөр Улсын Дээд, Доод хурал Сүй шу

* Сүй шу жаны Хүрээнд ирсэн цаг хугацааны хувьд янз бүрийн өдрийг заасан байх бөгөөд Д.Догсомын дурдатгалд хуучин тооллын 8-р сарын 19 буюу аргын 10-р сарын 13-ны хавьд гэжээ. Харин доктор Л.Жамсран 10-р сарын сүүлээр ирсэн гэсэн нь үнэнд дөхүү юм. Үүнийг доктор Ц.Батбаярын иш татсан "...Сүй шу жан Бээжингээс 1919 оны 10-р сарын 23-нд гарч, Чуулалт Хаалганаар дайрсан..." гэх Тайваны эх сурвалж бас тодотгож байна.

жаны тулгалтыг дагах эсэхийг тус бүрдээ хэлэлцэн, харилцан адилгүй шийдвэр гаргасан тухай түүхэнд өгүүлдэг.

Чухам үйл явдал хэрхэн өрнөсөнийг бага боловч тодруулваас: Дээд хурлаас дэд сайд чин ван лам Дашдэндэв, итгэмжит бэйс Цогт Очир нар ДИУ-д дагаж орох тухай мэдүүлэг бичгийг гаргаж өгөхөөр болсон талаар Доод хурлынханд уламжилсанд Доод хурлын гишүүн, залуус голдуу хэсэг (зохиогч улс төрийн мэдрэл бүхий гэж бичсэн Н.Х) Чингис, Чингис хэмээн хашгиралдаж, тус тус саналыг бичсэнийг Д.Догсом нэгтгэн "...Манай Монгол нь хятадын дарлагдлаас ангижирч газар нутгаа байлдан авахын тулд хятад лугаа удаа дараа байлдаан хийж, нэгэнт өшөөтөн дайсан бололцсон нь одоо хятадын гарт дахин орох болбаас урьдаас хувь илүү дарлагдах гашуун зовлонг үзэж болох тул, хятадыг дагаж захирагдахыг манай Доод хурлаас зөвшөөрөн баталж хэрхэвч чадахгүй. Хэрэв энэхүү хятадын цэргийн эрхтэн Сүй Шу жан цэргийн сүрээр айлган дагуулах байдал гаргаваас манай монгол цэргүүд цэргийн зэвсгийг гарт бүхий хамт даруй зэвсэг хөдөлгөн байлдаж сөнөөгөөд газар орноо батлан хамгаалж чадна" (20.7-8) хэмээн эсэргүүцжээ. Гэвч Дээд хурал "...цагийг таньж, хөрөнгө буурайн байдалд нийлүүлэхгүйгээр дайн байлдаан үүсвээс эцсээр олныг дийлж чадахгүйд хүрч хойчийн зовлон үлэмж болохоос болгоомжлох" нэрийдлээр Доод хурлын эсэргүүцлийг хүлээж авсангүйгээр үл барам "...хятадыг дагах аваас Богд хаан болон олон ноёд түшмэд ард хүртэл эрх завшааныг олох зүйл буй" хэмээн ятгахыг оролдсон аж. Тэдний байдлыг үйл явдлыг чих тавин сонсож мэдэхээр Дотоод яамны хашаанд цугласан олон ихэд шүүмжлэн, хэрэг явдлыг эрх баригчид эртнээс бэлтгэж, шийдвэрлэсэн зүйл бөгөөд тийнхүү Улсын хурлаар хэлэлцүүлсэн нь олныг хуурсан хэрэг хэмээн үзэж байжээ.

Ийнхүү Монголын автономит засаг унах нь өдөр цагаар хэмжигдэх болсон үед Монголын засгийн газар идэвхигүй, үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон гэмээр байсан гэхэд хилсдэхгүй. Ганц Улсын Дээд хурлын ирцээр л жишээ авахад эл байдал илэрхий болно. Ихэс дээдэс хувиа хичээн, элдэв өвчнөөр шалтаг хийж, хурлаас чөлөө хүсэх нь хирээс хэтэрсэн байлаа.

№	Хурлын өдрүүд	Өвчний учир чөлөө хүссэн	Улсын ажлын улмаас чөлөө лөгдсөн	Хуралд оролцоогүй нийт хүн, түүний дотор яамдын сайдууд
1.	1919.08.24.	30	3	33/11
2.	08.31	28	5	33/13
3.	09.07	33	3	36/16
4.	09.14	36	1	37/
5.	09.21	36	2	38/13
6.	09.28	28	11	39/16
7.	10.05	35	5	40/15
8.	10.12	19	6	25/11
9.	10.19.	26	7	33/13
10.	10.26.	41	8	49/18
11.	11.02.	41	8	49/16
12.	11.09.	38	4	42/13
13.	11.16.	52	3	55/17
14.	11.23.	47	7	54/13
15.	11.30.	42	2	42/13

Ийнхүү Улсын Дээд хурлын 1919 оны 8-р сарын 24-ээс 11-р сарын 30 хүртэлх 15 удаагийн хуралдааны ирцийг авч үзвэл доод тал нь 19, дээд тал нь 52 хүртэлх тооны гишүүд ханиад үгдэрсэн, хөл өвдсөн гэх зэргийн өвчин хэлж чөлөө хүссэн бол албаны ажлаар чөлөө авагсад удаа бүрд ердөө 2-оос 11-ийн хооронд хэлбэлзэж байжээ. Хамгийн сонирхолтой нь хурал бүрд 13-аас дээш тооны сайдууд оролцоогүй гэсэн тоо гарч байна. Энэ нь Монгол улсын 5 яамны тэргүүн, дэд ба хавсарсан дэд сайдууд Ерөнхий сайдтайгаа нийлээд 16 байдгийг бодолцвол төр ажиллахгүй болсоныг харуулна. Магадгүй өвчтэй гэсний цаана зарим нэг нь сэтгэл санаагаар унасан, нөгөө бусад нь үйл явдлаас хол байхыг хичээсэн зэргийн шалтгаан байж болох боловч ихэнхийнх нь идэвхигүй, эх

оронч бус байдал хятадын харгис хүчнийхний санал эрмэлзлэл бодит үйл хэрэг болоход дөхөм болсон гэхэд хатуудахгүй.

Ажил үүрэгтээ хойрго назгай хандсан Дээд хурал буй болсон нөхцөл байдлаас гарц олж чадаагүй бөгөөд олон түмний эсэргүүцэл шүүмжлэлийг үл хайхран Сүй шу жаны зохион өгсөн хятад эхийг монголоор орчуулан 5 яамны тамгыг дарж, Ерөнхийлэн шийтгэх сайд, Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яамны тэргүүн сайд чин ван лам Бадамдорж, дэд сайд чин ван Пунцагцэрэн, нягт билигт да лам Пунцагдорж, Гадаадын хэргийг бүгд эхлэн шийтгэгч яамны тэргүүн сайд хичээнгүй гүн Цэрэндорж, дэд сайд Далай чойнхор чин ван Цэдэнсоном, Ачит ван Гончигдамба, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэх яамны тэргүүн сайд эрдэнэ чин ван Жамъяндорж, дэд сайд эрдэнэ чин ван Сэлнэнтожил, эрдэнэ ван Пунцагравдан, итгэмжит бэйс Цогт Очир, Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэх яамны тэргүүн сайд бэйс лам Лувсанбалдан, дэд сайд бишрэлт ван Доржцэрэн, сүжигт бэйс Дэмчигваанжил, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яамны тэргүүн сайд Махасамади далай сэцэн хан Наваанцэрэн, дэд сайд дайчин жонон ван Цогбадрах, чин зоригт чин ван Дашдэндэв нарын 16 ноёд нэрийг жагсаан гардуулжээ. Түүнд: "...Хиагтын гэрээнээс инагш ДИУ-ын эзний эрх нэрийг хоосноор хүлээж, Гадаад Монгол ч мөн ашгийг хохирогдож, эрхийг алдсан бөгөөд хэдэн жил өөрөө зассанд мөн ч бүрэн бүтэн болохын төгсгөлийг үзсэнгүй" гээд "... өөрөө засах засгийн газрыг үг нийлэлдэн дуртай устгаж урьдах Чин улсын хуулийг дахин хүлээж Думдад засгийн газраас Гадаад Монголыг хүндэтгэн үзэх ба хойчийг сайжруулах хууль зүйлийг тогтоох"-ыг гуйжээ (21.)

Бичигт Богд хаан мутрын тамгаа дарсангүй. Энэ ч бас учиртай. Монголын тусгаар тогтнолыг үл зөвшөөрөн элдэв зүйлийн үг өгүүлбэр бүхий цахилгаан утас ирүүлж байсан Юань Шикайн мэдэгдэл, байр байдлаас ДИУ-ын Монголын талаархи бодлогыг ойлгосон Богд хаан хойчийн аюулыг төсөөлж байсан учир тийнхүү гадна үлдсэн байна.

Зорьсон хэргээ гүйцээж чадсан Сүй шу жан өргөдлийг хүлээн авч Хятадын ерөнхийлөгчид уламжилсан аж. Энэ тухай "Миньго Жибао" хэмээх сонинд дэлгэрэнгүй мэдээлсэнийг доктор Ц.Батбаярын номоос иш татан өгүүлбэл: 1919 оны 11-р сарын 22-ны дугаарт Сүй шу жан Монголын автономитийг устгах тухай бичгийг хэрхэн гаргуулан авсныг тодорхой өгүүлээд Бээжин Хиагтын гэрээг цуцлахаар бэлтгэж байгааг мэдээлэхийн хамт Монголын тал бичгийг өгөхдөө гурван зүйлийн нөхцөл тавьсаныг дурджээ. Энэ нь нэгдүгээрт, хэрвээ Монголын хил хязгаарыг хамгаалахаар хятад цэрэг илгээх тохиолдолд Хүрээний Засгийн газраас [Засгийн газар гэснийг анхаарах Н.Х] зөвшөөрөл авч байх, Гадаад Монголын урьд өмнөх өр зээлийг Төв Засгийн газар төлж барагдуулах, Гадаад Монголын ван гүнгүүдийн эрх ямбыг хадгалах тухай тусгай хэлэлцээрийг байгуулах зэрэг болно (22.43-44). Энэ нь монголчууд өөртөө засах засгаа зүгээр нэг найр тавиад өгчих бодолгүй байсныг харуулна.

Бээжинд үйл явдал тийн өрнөж байх зуур Хүрээнд яамдын бичиг данс бичиг, байшин, сав хэрэглэл, цэргийн зэвсгийг бүртгэн, Хятад яамнаа бүрэн тушаан өгөхөд бэлтгэх ажлыг далдуур хийж эхэлжээ. Удалгүй 1919 оны 11-р сарын 22-нд Хиагтын гурван улсын гэрээг цуцалж, Монголын өөртөө засах эрхийг халсан тухай ДИУ-ын ерөнхийлөгчийн зарлиг гарч, тэрбээр "...Монголын төрийн тэргүүн Богд Жибзундамба болон ван гүн нарын хүссэнээр Гадаад Монгол Хятадын газар нутагт багтан орох болсонд сэтгэл ханамжтай байгаа" (23.95) "гаа илэрхийлэхээ мартсангүй. Энэ бол монголчуудын үндэсний тусгаар байдлыг хүч түрэмгийлэн устгасаныгаа Монголын эрх баригчдын хүсэл эрмэлзлэл байсан мэтээр харуулахыг эрмэлзсэний илрэл мөн. Монголын үндэсний төр улсын хувьд бие даан оршин тогтнох эрхийг нь хаант Оростой хавсран хязгаарласан хятадууд энэ удаа тусгаар байдлынх нь сүүлчийн илэрхийлэл болж байсан өөртөө засах засгийг нь хүч түрэн устгах зорилгодоо ийнхүү хүрчээ.

Зарлигийг Монголын Гадаад яам 12-р сарын 16-нд олон хошуудад зарлан мэдэгдэв.

Монголчуудын үе үеийнхний тэмцлээр үнэ цэнэтэй олдсон эрх чөлөө тусгаар байдал амар хялбар алдагдсан нь хятадын харгис хүчний дэс дараатай бодлогын үр дүн мөн боловч Монголын эрх баригчдын зарим нэгний аймхай хулчгар, арчаагүй, урвамтгай байдлын уршиг байсныг бас үгүйсгэх ёсгүй. Энэ нь хятадыг эсэргүүцэн тэмцэхээ

илэрхийлсэн Улсын Доод хурлын шийдвэрийг анхнаасаа л хүлээн аваагүй эрх баригчид үндэсний цэргээ тараалгах үедээ дан ганц Нийслэл Хүрээнээс "төрөл бүрийн буу 9187, сум 1690 862, сэлэм 9608" (3.161)-ыг Хятадын цэрэгт шилжүүлэн өгч байсан, мөн зүүн хязгаараас "... Хятадад дагаж болохгүй. Хятад ба улаан Орос хоёуланг нь оруулахгүй сахихыг би батлан хүлээнэ"(24.29) хэмээн Манлайбаатар Дамдинсүрэнгийн довтолгон ирүүлсэн захидлыг нуун дарагдуулсан зэргээс илэрхий.

Хэдийгээр зарим түүхчдээс автономит засаг унасан явдлыг тухайн цаг үеийн аргагүй нөхцөл байдалтай холбон үзэх нь байх боловч, Монголын эрхийг барьсан сайдууд хятадын эсрэг удаа дараа тэмцэж явсан дайчин баатрууд, Хужирбулангийн сургуулиар бэлтгэгдсэн цэрэг дарга нар, хил хязгаарыг сахиулан суусан цэрэг анги зэрэг дотоодын хүчнээ нэгтгэн зохион байгуулж чадаагүйгээр үл барам ганц хоёрхон удаагийн сүр үзүүлсэн тулгалтын дараагаар автономит эрхийг нь цуцлах замаар үндэс угсааг нь устгахаар ирсэн хятад сайдын өмнө бууж өгсөн нь үнэн зүйл. Үүнийг Монголын түүхч Л.Дэндэвийн "...улс төрийг батлан хамгаалах үндэсний цэргийг зүй зохистойгоор байгуулж чадсангүй нь улс төрийг мөхөөх сөнөөх замд учруулахын бэлтгэл" (16) болсон гэж дүгнэсэн байдаг. Ямар ч атугай тухайн үед Хүрээ хотгүй

Богц богц мөнгөөр

Богдыгоо худалдсан сайдууд гуай

Хүүдий хүүдий мөнгөөр

Хүрээгээ худалдсан сайдууд гуай

Дэнс дэнс мөнгөөр

Дэлхийгээ худалдсан сайдууд гуай хэмээн зэвүүцэн дуулж байсан нь бодит байдлын илэрхийлэл гэлтэй.

1920 оны I сарын 19-нд Монголын өөртөө засах засгийг устгасан тухай ёслолыг Сүй шу жан Хүрээнд их л сүржнээр хийсэн бөгөөд энэ тухай хятадын түүхчид хожим нь "...Гадаад Монголын "өөртөө засах" гэсэн дэлхий дахиныг донсолгосон их хэцүү асуудлыг гайхамшигтайгаар зохицуулсан нь түүхийн хуудаснаа үүрд үлдэх хэрэг мөн" (22.91-93) хэмээн дүгнэж, түүнийг гүйцэтгэсэн Сүй Шу жаныг ихэд өргөмжилжээ. Тэр тусмаа "... үнэн чанартаа том хэрэг явдал байсан" хэмээн хятадын түүхчдийн бичсэнээс үзвэл, үнэхээр л тэр үед хятадууд хоолой дээрээ тээглэсэн ясыг авч хаясан мэт болж байсан бололтой.

Гэхдээ энэ нь өмнө өгүүлсэнээр бүс нутгийн улс хоорондын зөрчил зөрөлдөөн, үйл явдлын дундаас хятадууд хожил гаргаж чадсан түр зуурын л явдал байв. Монголчууд автономит засгаа устгуулсанаа тэвчиж чадахгүй нь хэнд ч илэрхий байсан бөгөөд гагцхүү цаг хугацааны асуудал байсан нь дараагийн үйл явдлуудаас тодорхой болно.

Резюме: В настоящей статье автором сделана попытка выяснить причины ликвидации автономии внешней Монголии в контексте региональных событий, таких как установление военной власти в Китае, уход России из Монголии в связи с участием в мировой войне и внутренними неурядицами Панмонгольское движение. Автором уделено значительное внимание рассмотру вопроса об усилиях монгольских правителей отстоять свою автономию, благодаря чему китайским властям пришлось использовать самые различные меры вплоть до применения военных сил.

Эшлэл

1. Хятад,Орос,Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. (Өдөр тутмын тэмдэглэл). Баримт бичгийн эмхтгэл. Эмхтгэж тайлбар бичсэн О.Батсайхан. УБ., 1999.
2. Н.Магсаржав. Монгол улсын шинэ түүх. УБ., 1994
3. Л.Жамсран. Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт. УБ., 1997
4. Н.Хишигт.Монгол улсаас хаант Оростой цэргийн салбарт байгуулсан гэрээ хэлэлцээрүүд-//Түүхийн судлал. Том XXXIII:Favs 1. УБ., 2002. т. 6-18.
5. Дорогой дружбы. Сб. Статей. Ирк., 1971.

6. С.Г.Лузянин.Россия-Монголия-Китай в первой половине XX века. Политические взаимоотношения в 1911-1946 гг. (Издание второе, исправленное и дополненное). М., 2003.
7. Е. А. Белов. Россия и Монголия (1911-1919гг).М.,1999.
8. Болд.Монголын тусгаар тогтнолын талаарх АНУ-ын үзэл хандлага,байр суурь, бодлого (1910-1973). Доктор (Ph.D)-ын зэрэг горилсон зохиол. УБ.,2007.
9. И. Я. Коростовец.От Чингис хана до Советской республики (Краткая история Монголии с особым учётом новейшего времени).УБ., 2004.
- 10.УТА. Ф.445. д.1. хн.2.
- 11.Чен Цун зо. Гадаад Монголын ойрхи үеийн түүх. Бээжин-Шанхай. 1922.
- 12.М.Ариунсайхан. Гадаад Монголын автономитийг устгасан тухай асуудалд-//Түүхийн судлал. Т.25. УБ., 1990.
- 13.Эльбек-Доржи Ринчино о Монголии. Улан-Удэ., 1998.
- 14.Б.В.Базаров. Неизвестное из истории Панмонголизма. Улан-Удэ., 2002.
- 15.Түүхийн хүрээлэнгийн ф.2.т.1. хн.544.
- 16.Л.Дэндэв. Монголын товч түүх.(Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар нэрсийн хэлхээ хийсэн С.Чулуун) .УБ., 2006.
- 17.Фүтаки Хироши. Нармай Монгол Улсын түр засгийн газар байгуулагдсан нь, Токио гайкокүго дайгакү, роншюү №54.1997; Б.Икома Масанори. Сибирийн дотоод дайн ба Буриад Монголын асуудал, Сүравиа кэнкюү №41.1994-// Т.Мөнхцэцэг. Япон дахь Монголын түүхийн судлагаа. (1990-2005).УБ.,2006
- 18.УТА. ФА4. д.1. хн.83
- 19.Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан. Ф.5. т.161.хн.90
- 20.“Гишүүн М.Дугаржаваас Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооноо” - //Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан. Ф.3. т.116.хн.1148
- 21.Автономит Гадаад Монголын Засгийн газрын бичиг. ДИУ-ын 18-р он. 11сарын17. Монголын шаргачин хонин жил. 9 сарын 25 - УТНС. Гар бичмэл.
- 22.Ц.Батбаяр. Монгол ба Их гүрнүүд XX зууны эхний хагаст. УБ., 2006
- 23.Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц үгсэл).Бээжин.,1993-// ОУСХ-ийн номын санд буй монгол орчуулга .
- 24.Жанжин Манлайбаатар Дамдинсүрэн түүний шинэтгэлийн бодролууд. УБ., 1991